МЭДЭЭ · 2022 оны 9-р сарын 5

ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛСЭН ХЭРГИЙН ДИЙЛЭНХ НЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ БАЙНА



Прокурорын байгууллага өнгөрсөн долоо хоногт буюу 2022 оны 8 дугаар сарын 29-нөөс 9 дүгээр сарын 02-ны өдрүүдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос гаргасан 255 гомдол, хүсэлтийг шийдвэрлэж, мөрдөгч болон зөрчлийн хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтанд тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр 410 даалгавар бичгээр өгсөн байна.

Гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар байгууллага, албан тушаалтанд 23 мэдэгдэл, зөрчил шалган шийдвэрлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх явцад гарсан зөрчил, түүнд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар хяналтын харьяа байгууллагуудад 12 шаардлага тус тус бичиж хүргүүллээ.

Түүнчлэн мөрдөн байцаалтын 2400 хэрэгт хяналт тавьж, 267 хэргийг яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж шийдвэрлэлээ. Тодруулбал, Эрүүл мэндийн халдашгүй

байдлын эсрэг 165, Өмчлөх эрхийн эсрэг 72, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 30, Бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 10, Хүний амьд явах эрхийн эсрэг 8, Хүрээлэн байгаа орчны эсрэг 5 хэрэг байгаа бол Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах болон Авлигын тус бүр 4 хэргийг шүүхэд шилжүүлсэн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1918